

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл ажиллагааны мэдээлэл**

Петро Матад компанийн Давсан Толгой-10 цооног (ДТ-10) нь геологийн даалгавар болох Цагаанцавын доорх галт уулын хэмхдэст суурь чулуулаг буюу 1740м хүртэл өрөмдөж дууссаныг Компани мэдэгдэж байна. Өрөмдлөгийн ажил дуусч, цооногт геофизикийн бичиглэл хийгдэж петрофизикийн дүн шинжилгээ хийгдсэн. Тус ДТ-10 цооногт хөдөлгөөнт нүүрсустөрөгч илрээгүй бөгөөд цооногийг таглаж битүүмжиллээ.

ДТ-10 цооног нь Компанийн Шороо ба Гал хэтийн төлөв сайтай талбайнуудын дунд тусад нь байрлах бүтцийн хураагуурыг өрөмдсөн. Тус цооногийн геологийн даалгаварууд нь нэгдүгээрт Доод Цагаанцав, хоёрдугаарт Баруун Урд Өвгөн Голын захад байрлах Хамгийн дээд Цагаанцавын формацууд байсан. Тус цооног нь Хамгийн дээд Цагаанцавын формацад 45м агуулагч давхрага болж чадахгүй шаварлаг үе, Доод Цагаанцавын формацад 335 метрээс дээш зузаантай элс, шаврын үеүүдийг өрөмдсөн бөгөөд өрөмдлөгийн үед тосны илрэл харагдаагүй, мөн петрофизикийн дүн шинжилгээгээр зөвхөн тос дамжиж өнгөрсөн байж болох шинж тэмдэг бүхий салангид нимгэн үеүүд тогтоогдсон.

Өрөмдлөгийн цамхаг дараа нь ДТ-1 цооногоос урагш 225 метрт байрлах цэгт нүүж очно. ДТ-11 цооног нь формацийн гэмтэлтэй байж магадгүй гэж үзэж битүүмжилсэн ДТ-1 цооногийг орлуулан өрөмдөх цооног юм(2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 1970N дугаартай мэдээг харна уу). ДТ-11 цооногийн өрөмдлөг 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр эхэлж байгаа долоо хоногт эхлэнэ гэж тооцоолж байгаа бөгөөд өрөмдлөг эхлэх хуваарьт ямар нэгэн том өөрчлөлт гараагүй тохиолдолд дахин шинэ мэдээ тавигдахгүй.

Петро Матад Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй хэлэхдээ "ДТ-10 цооногт нүүрсустөрөгч илрээгүй нь харамсалтай боловч нүүрсустөрөгч цуглаж байгаад алдагдсан нотолгоог бид дахин олж харлаа. Давсан Толгойд үүсээд байгаа одоогийн зураг бол ээдрээтэй давхрагазүй болон бүтэцийн тогтоцын ярвигтай түүх юм. Энд хийх хайгуулын ажилд ихээхэн хэмжээний өрөмдлөгийн ажил шардлагатай. Тэмдэглэж хэлэх нэг сайн тал бол бидний зураглал хийж тайлсан сейсмийн мэдээлэл дээр харагдаж байгаа бүтцүүдэд нүүрсустөрөгч шилжиж ирсэн гэдгийг үргэлжлүүлэн баталсаар байгаа явдал билээ. Бодит байдал дээр бидний өрөмдсөн нийт 10 цооногоос зөвхөн нэг цооног ор тас хуурай байна. Мэдээж бид илүү том амжилтыг мэдээлэхийг хүсч байгаа бөгөөд газрын тос маш хол замыг туулж давхрагазүйн хураагуур болон хэд хэдэн өөр төрлийн бүтцийн хураагуурт хуримтлагдсаныг өрөмдлөгийн ажил тогтмол харуулсаар байна. Цөхрөлтгүй хайгуулын ажил, их хэмжээний өрөмдлөгийн хамтаар ирээдүйд Давсан Толгойгоос эдийн засгийн үр ашигтай олборлолт хийх болно гэдэгтээ бид итгэлтэй байгаа.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Ерөнхий Геофизикч Доктор Курт Констениос хянасан болно. Доктор Констениос нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич, геофизикч юм. Тэрээр Америкийн Газрын

Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100